

ДАЙЧИН ВАНГИЙН ХҮРЭЭНИЙ ТҮҮХЭЭС

Н.Хатанбаатар

Өгүүллийн товч утга: Халхын томоохон хүрээ хийдийн нэг Дайчин вангийн хүрээний түүхийг хураангуйлан өгүүлжээ. 1666-1667 онд уг хүрээний суурийг Түшээт хан Чахундоржийн дүү Сэдшир баатар үндэслэсэн хэмээх таамаглал дэвшүүлсэн байна. 1937-1938 оны улс төрийн хэлмэгдүүлэлтийн үе уг хүрээ устаж үгүй болжээ.

Түлхүүр үг: Түшээт хан аймаг, Дайчин вангийн хошуу, Дайчин вангийн хүрээ, Баатар бэйл, хошуу засаг, өргөө, дацан, сүм, түүх, соёлын дурсгал

XIX-XX зууны эхэн үеийн Ар Монголын шашин мөргөл, аж ахуй-эдийн засгийн томоохон төв, зангилаа газрын нэг бол Дайчин вангийн хүрээ байв. Энэ хүрээ нь Халхын Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны гол хүрээ хийд болох учраас хошуу засгийн цолоор Дайчин вангийн хүрээ буюу товчоор Вангийн хүрээ хэмээн алдаршжээ.

Дайчин вангийн хошуу нь Халхын төв нутагт оршдог бөгөөд газар нутаг, хүн ам, мал хөрөнгөөрөө тэр үеийн томоохон хошуудын нэг байсан билээ. Хошууны засаг ноёд нь ч тухайн цаг үеийнхээ нийгэм-улс төрийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэж явсан нөлөө бүхий язгууртнууд байв.

Вангийн хүрээний үүсэл. Вангийн хүрээ нь Ар Монголын сүм хийдүүдийн дотроос эртний хийдийн тоонд орно. Учир нь XVI зууны сүүлээс Монголд бурхны шашин дэлгэрч, 1586 онд Эрдэнэ зуу хийд байгуулагдсанаас хойш одоо мэдэгдэж байгаагаар 1580-аад оны сүүлчээр Түмэнхэн сайн ноёны сүм суварга, 1612 онд Хөгнө Тарнийн өвгөн хийд, 1647 онд Баруун хүрээ, 1651 онд Их хүрээ зэрэг Халхын анхны сүм хийдүүд байгуулагдсан бүлгээ. Тэгвэл түүхийн сурвалж бичиг ба архивын баримтаас үзэхэд, Вангийн хүрээний үндэс суурь нь 1666-1667 онд Түшээт хан Чахундоржийн ойр төрлийн Баатар бэйл хэмээгч өөрийн орд гэрийг цогчин сүм болгож үүсгэснээр тавигдсан бөгөөд нэлээд хугацаанд суурьшилгүй тэрхүү Баатар бэйл ноёны өргөөг даган нүүдэллэн явснаас Вангийн өргөө хэмээн нэрлэгдэж байжээ¹. Энд дурдагдаж буй Баатар бэйл гэгч нь Түшээт хан Чахундоржийн дүү Сэдшир баатар болов уу хэмээн үзэж болхоор байна. Учир нь Сэдшир баатар нь XVII зууны сүүлийн хагасын Халхын улс төрийн амьдралд идэвхтэй оролцож явсан бөгөөд 1691 онд Долнуурын чуулганаар Манжийн төрөөс

¹ ТЕГ-ын Түүхийн Архив. Шашны хэрэг эрхлэх газар. Булганы хүрээний түүх. Ф-6, ХН-256.

- Лигшиддонгайлин хийдийн 15-р жарны модон туулай жилийн /1915/ лит /хуанли/-ийн хуулбар. Булган аймгийн орон нутаг судлах музей.

засаг бэйлийн хэргэм өргөмжлөгдсөн билээ. Тэр үеэс Сэдширийг бичиг зохиол ба аман ярианд Баатар бэйл хэмээн нэрлэж байсан бөгөөд түүний үр хойч нь хожмын Түшээт хан аймгийн Зоригт засгийн хошууны засаг ноёд болно. Чингэвэл, Вангийн хүрээг Түшээт хан аймгийн Сэдшир баатар анх үндэслэсэн бөгөөд түүний эзэмшил газарт уг хийдийн эх үүсвэр тавигдсан гэж үзэж болох буй заа.

Вангийн өргөө нь 1686 онд Түшээт хан аймгийн Дайчин вангийн хошууны анхны засаг ноён Чамчугнамжилын үед тус хошууны нутгийн өмнөд этгээд Ачуут хэмээх газар буюу одоогийн Монгол улсын Булган аймгийн төв, Булган уулын зүүн урд үзүүр Ачуут зүүн түрүү хэмээх Хужир голын бэлчирт суурьшсанаар Дайчин вангийн хошууны гол хийд болжээ².

Хүрээний бүтэц, зохион байгуулалт. XVII зууны сүүлч, XVIII зууны эхэн үеэс Вангийн хүрээнд сургууль хурлын олон дацан, аймгийн сүмүүд удаа дараалан байгуулагдаж өргөжжээ. Үүнд 11-р жарны усан гахай жил /1673/ онд Дашпэлжээлин аймаг, модон үхэр жил /1685/ Дашчойнхорлхүмбэ буюу Цогчин хурал, гал үхэр жил /1697/ Самданчойлин аймаг, шороон үхэр жил /1709/ Пунцагдоналин аймаг, төмөр үхэр жил /1721/ Дашчойлин аймаг, усан үхэр жил /1733/ онд Дашчойнхорлин аймаг, модон үхэр жил /1745/ Ганданпилжээлин аймаг, шороон луу жил /1748/ Жанчивлин аймаг болон Пунцаггэжээ /1796/, Гиваапэлжээ /1807/, Дондовлин /1830/, Чойнхорлин /1830/, Гунгаадаржаалин /1892/ зэрэг бүгд 12 аймгийг байгуулжээ. Тэрчлэн усан хулгана жил /1779/ Цанид дацан, шороон тахиа жил /1789/ Эмч.нар дацан, төмөр луу жил /1803/ онд Зүүн Жүд дацан, 1807 онд Зурхайн дацан, 1873 онд Баруун Жүд зэрэг 5 сургуулийн газар болон Гүнрэг •/1871/, Дүйнхор /1811/, Майдар, Жанчивлин /1749/, Диваажин, Жанрайсиг, Хайлан, Норжиндэжээлин /1913/ зэрэг олон дацангуудыг сүм дуганы хамт барьж байгуулж суурьшуулжээ³.

Өмнө өгүүлснээс үзвэл, Дайчин вангийн хүрээний засаг захиргааны зохион байгуулалтын үндсэн нэгж нь Монголын бусад сүм хийдийн адил аймаг байжээ. Тус хүрээний 12 аймаг нь тус бүрдээ өөрийн шүтээн ба өдөр тутмын хурал хурах дугантай байсан аж. Үүнээс гадна Вангийн хүрээнд бурхны шашны их, бага таван

² ТЕГ-ын Түүхийн Төв Архив. Шашны хэрэг эрхлэх газар. Ф-6, ХН-256.

-МУУТА. ФА-3, Д-1, ХН-1121.

³ МУУТА. ФА-3, Д-1, ХН-1121.

-ТЕГ-ын Түүхийн архив. Ф-6, ХН-256.

- Лигшиддонгайлин хийдийн 15-р жарны модон туулай жилийн /1915/ лит /хуанли/-ийн хуулбар. Булган аймгийн ОНСМ.

ухааныг заан сургадаг Цанид, Эмч нар, Жүдийн хос дацан, Зурхай гэсэн 5 сургуулийн газар буюу дацан байсан нь мэдэгдэж буй. Мөн бурхны шашны хурал номын чиглэлээрээ ялгагдаж буй 10 гаруй хурал дацан ажиллаж байжээ. Дээр дурдсан дацан хурлуудад цаг цагийн олон хурал хурахын дээр хавар, намар хоёр цагийн аграмбын 16 дамжаа найман хоног, жасаа хурал гүйцэт хурна. Харин зурхайн дацанд олон зүйлийн хурал цаг цагт хурахын дээр жасаа хурал нэг зуун тавь хоног, зээрэмбийн мяндагийн дамжаа зургаа хоног хурдаг байв⁴.

XX зууны эхэн үеийн байдлаар Вангийн хүрээ нь Ар Монголын нөлөө бүхий томоохон хүрээ хийдийн нэг болон өргөжиж, нийт 3700 орчим лам нар нь 12 аймагт хуваагдан сууж байснаас гадна тэнд хурал сургуулийн 27 дацан, 30 орчим дуган жас оршиж байсан мэдээ бий¹³. 1866 онд Вангийн хүрээнд Их Майдар бурхныг бүтээн, Гандандамбаалин сүм байгуулахад байрлуулан залжээ. Мөн засаг хошой чин вангийн зэрэг Цэрэндоржийн үед буюу 1876 онд Диваажин ба Жаргалын орон гэдэг нэртэй хиймэл уулан дээр сүм байгуулж, 1904 онд сүрлэг үзэсгэлэнтэй цагаан суваргыг барьж дуусгажээ. 1919 онд Эрдэнэ дайчин ван Жамбалдоржийн үед тус хошууны Рашаант хэмээх газар сүм байгуулж, VIII Богд Жибзундамба хутагтад айлтгахад, Ёндондаржаалин нэр шагнаж, да лам тушаалыг бий болгож, уг сүмийн хэргийг шийтгүүлжээ⁵.

Ийнхүү Вангийн хүрээ нь түүхийн явцад өргөжин хөгжсөөр XIX зууны эцэс, XX зууны эхэн үеэр хүн ам олонтой, хөл хөдөлгөөнтэй багахан хот болоод байсан тухай тэр үед тус хүрээгээр дайрч гарсан худалдаачид, жуулчдын тэмдэглэлд өгүүлсэн нь буй⁶.

Лам нар. Дайчин вангийн хүрээ нь лам нарын тоогоороо Ар Монголын сүм хийдүүдийн дотор дээгүүрт орж байв. XVII-XIX зууны үеийн тус хүрээний лам нарын нийгмийн бүтэц, бүрэлдэхүүн, тоог нарийвчлан тодорхойлсон бүрэн хэмжээний бүртгэл одоогсор олдоогүй байна. Архивын баримтаас үзвэл, Манж Чин улсын Төр гэрэлтийн үед буюу 1823 онд тус хүрээний нийт лам нарын тоо 1221 байсан мэдээ бий. 1831 оны Дайчин вангийн хүрээний лам нарын бүртгэлд “да лам гэлэн Лувсанчойсүрэн, дэд лам гэлэн Наваанбалдан, дэмч лам гэлэн

⁴ Мөн тэнд.

¹³ И.М Майский. Монголия накануне революции. М., 1959. стр.122.

⁵ МУУТА. ФА-3, Д-1, ХН-1121.

⁶ Боголепов М.И., Соболев М.Н. Очерки торговли русско-монгольской. СПб., 1912. стр.100-101. – А.М Позднеев. Монголия и монголы. СПб., 1896. стр.92.

Наваанцэдэн гэх зэргээр гэлэн 22, гэцэл 15. энэ лам бүгд 40¹⁴ гэжээ. Мөн засаг Цэрэндоржийн үед хурлын лам нарын нэр, нас, тоо зэргийг мэдүүлж өргөсөн цэсэнд “хурлын лам рабжамба гэлэн Лувсаншарав, да лам гэлэн Наваанлуvsан, дэмч гэлэн Лувсаншарав, гэвхүй гэлэн Лувсанлэгдэв, шавь гэлэн Ишгэлэг, тайж лам Жамсранжав, Цэрэндаш, Усанбалин” гэх зэргээр гэлэн 33, гэцэл 8, тайж лам 3 хэмээн тэмдэглэжээ⁷. Энэ нь Манжийн төрийн хуулийг баримтлан хүрээнд байнга шавилан суудаг зөвхөн томхон лам нарыг голлон оруулж тооцсон бүрэн бус мэдээ юм. Чухамдаа лам нарын тоо үүнээс хэд дахин олон байсан нь дамжиггүй.

XX зууны эхэн үед Дайчин вангийн хүрээний лам нарын тоо урьдахаас нэлээд олширч, Халхын хамгийн олон ламтай хүрээ хийдийн нэг болжээ. 1911 оны байдлаар тус хүрээний лам нар 2818 байсан бол 1918 онд 3679, улмаар 1921 онд 3722-д хүрчээ. Харин 1936 оны Дотоод Явдлын Яамны Шашны хэрэг эрхлэх газраас Сэлэнгэ аймгийн Булган сумын сүм хийд, лам нарыг бүртгэсэн данснаас үзвэл, “Булганы хүрээнд /Вангийн хүрээ-Н.Х/ шавилан сууж буй нийт лам нар 1467 байсны дотор тушаалтан лам 457, мяндагтан лам 277, бусад нь энгийн лам нар байжээ⁸.

Дайчин вангийн хүрээний лам нар нь албан тушаалын зэрэг дэв ба эрдмийн мяндаг цолоороо хоорондоо ялгаатай эрэмбэ шатанд хуваагдаж, тэдгээр нь харилцан адилгүй эрх ямба, нийгмийн байр суурьтай байв. Судлаачид лам нарыг дотор нь а/ хутагт хувилгаад болон мяндаг тушаалтай лам нар б/Дунд хэсгийн лам нар в/Доорд хэсгийн хувраг гэж хувааж үздэг. Үүнээс гадна тэдгээр лам нарыг дотор нь бас мяндаг тушаалтан лам нар ба энгийн лам нар гэж хоёр ялгаж болно. •Мяндаг тушаалтан лам нар тоогоор цөөн бөгөөд тухайн хүрээ хийдийн эрхийг баригчид юм. Хошууны хүрээ хийдийн да лам, гэгээн хутагт нар нь их төлөв засаг ноёны хөвгүүн буюу ойр төрлийн хүн байх нь түгээмэл байжээ. Тухайлбал, ван Цэдэндорж төрсөн хөвгүүн хүрээний дэд хамба, тайж лам Лувсаннамжилд өөрийн хамжлагаас 9 хүнийг шилжүүлэн өгч байсан мэдээ байна⁹.

Вангийн хүрээний нийт ажлыг гол Цогчин дуганы газраас шууд эрхлэн явуулах бөгөөд хийдийн эрх баригч гол албан тушаалтнууд нь тэргүүн хамба лам-1, дэд хамба-1, дэмч гэсгүй-1, да лам-1 байжээ. Тэдгээр эрх баригч тушаалтнаас

¹⁴ МУУТА. М-14, Д-1, ХН-19.

⁷ МУУТА. М-14, Д-1, ХН-1.

⁸ ТЕГ-ын Түүхийн Архив. Ф-6, ХН-256.

⁹ МУУТА. М-14, Д-1, ХН-1

тус хүрээний бүхий л ажлыг шууд тушаах буюу удирдах зэрэг бүрэн эрхийг эдэлж, хүрээний дацангууд ба 12 аймгийн хэргийг захирах буюу таслан шийтгэх эрх бүхий байв¹⁵. Дацан хурлууд нь дотроо лам, гэвхүй да зэрэг тушаалтанд бүрэн захирагдаж, хурал номын ажлыг эрхлэн гүйцэтгэдэг байжээ. Дээр дурдсан хүрээний эрх барих дээд лам нарыг хурлын тушаалтан гэдэг байв. Үүнээс тэргүүн хамба бол хүрээ хийдийн хамгийн том тушаалтан, дэд хамба тэргүүн хамбыг орлож, хүрээ хийдийн бүх ажлыг хянан явуулдаг байв. Мяндаг тушаалт том лам нар бол сүсэгтний өргөл барьц болоод бусад орлоготой ажил эрхэлдэгийн хувьд ихээхэн хөрөнгөлөг байжээ. Хийдийн мяндаг тушаалгүй лам нар нь энгийн ардаас их төлөв гаралтай, хүрээ хийдийн хөрөнгө баялагийг зарцуулах, хэрэглэх эрхгүй, харъяат хийдийн ажлын голыг нугалагсад байв.

XIX зууны сүүл, XX зууны эхэн үед Монгол оронд сэхээтний бүлгийг лам нар голлон бүрдүүлж байсан гэх бүрэн үндэстэй юм. Ер нь лам нарын ихэнх нь бүтээллэг үйл ажиллагаа явуулдаггүй, өвөрмөц онцлогтой бүлэг юм. Лам нарын дотор их төлөв ядуу, дунд ардаас гаралтай бөгөөд шашны номлол, гүн ухаан, зурхай, эмнэлэг зэрэгт мэргэшин, гавж аграмбын зэрэг хүртэн дээд лам нарын эгнээнд шилжих явдал гарч байжээ. Тухайлбал, Дайчин вангийн хүрээний Дандар аграмба хэдийгээр харц ард гаралтай боловч буддын гүн ухаанд нэвтэрч, гавжийн дамжаа барьж, Далай лам хүртэл түүний ухааны цар, номын шидийг бишрэн, шавь орж, олонд шагшигдаж байсан нь түүхэнд үлджээ. Мөн Дандар аграмба эртний Энэтхэгийн нэрт гүн ухаантан Асанга, Дхарямакирти, Камалашила, шарын шашныг үндэслэгч Зонхова зэрэг сэтгэгчдийн зарим зохиолд тулгуур тайлбаруудыг хийсний дээр Ганжуур, Данжуурын монгол хэвлэлийг шүүн үзэж, түүнд гарсан үг үсгийн болоод утгын алдаа, мэдгийг тодорхойлсон ариутгалыг хийсэн ажээ¹⁰.

XVIII-XX зууны эхэн үеийн Монголын нийгмийн бүтцэд байсан сонин үзэгдэл бол лам өрх гэгч юм. Академич Ш.Нацагдорж Түшээт хан аймгийн арваад хошууны хүн амын тоо бүртгэлээс үзээд, зарим хошууны бүх өрхийн тэн хагас буюу түүнээс ч илүү хувь нь лам өрх байгааг тогтоожээ¹¹. Тэдгээр нь орон хийдэд байнга шавилан суугчид биш, харин хөрөнгө мал бүхий хөдөөний лам нар юм. 1836 оны тооллогоор Дайчин вангийн хошуунд ноёны хамжлага дотор 93 лам өрх, тайж

¹⁵ ТЕГ-ын Түүхийн Төв Архив. Ф-6, ХН-256.

¹⁰ Ж.Болдбаатар. Далай ламын монгол багш. УБ., 1996. тал 20.

¹¹ Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978. тал 216.
-БНМАУ-ын нийгмийн бүтэц. УБ., 1984. тал 17.

нарын хамжлагын дотор 15 лам, хуяг эрийн дотор 84 лам өрх тус тус бүртгэгдсэн байна¹². Эдгээр нь шашны томоохон хурал ном, баяр ёслолын үеэр Вангийн хүрээнд хуран цуглардаг байжээ. Үүгээр зогсохгүй Манжийн алба татвар хүндэрч, тайж нар албанд өртөх болсонтой холбоотойгоор язгуур угсаатай тайж нар ч лам болох явдал нэлээд олширч байжээ. Тухайлбал, 1823 оны байдлаар тус хошууны тайж лам нарын нэр тоог мэдүүлж өргөсөн цэсэнд 53 тайж лам бүртгэгдсэн нь тухайн үед байсан нийт тайж нарын тал нь болж байв¹³.

Аж ахуй-эдийн засгийн амьдрал. Дайчин вангийн хүрээний аж ахуйг эрхлэн тооцох байгууллага нь Монголын бусад сүм хийдийн адил жас байв. Жас нь нийтийн өмч хөрөнгө гэсэн утгатай түвэд үг бөгөөд тухайн хүрээ хийдийн хурал номын зардал болон лам нарын хэрэгцээг хангаж нийлүүлэх үүрэгтэй аж ахуйн байгууллага байв. Вангийн хүрээ нь үүсэн байгуулагдсанаас хойш өргөжин тэлэхийн хирээр аж ахуйн үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдэж, олон жасууд буй болсоор байжээ. 1918 оны байдлаар Вангийн хүрээний аймаг дацан, хурал номын хэрэглэл албадыг нийлүүлдэг нийт 30 орчим жас байжээ. XIX-XX зууны эхэн үед тус хүрээний жасууд нь мал сүргийн тоо толгой, эд хөрөнгө, эдийн засгийн хүчин чадал, орлогоороо Монголын сүм хийдүүдийн доторт дээгүүрт ордог байжээ. 1930-аад оны үед ардын засгаас шашин, сүм хийдийг хавчих бодлогын улмаас тус хийдийн аж ахуйн хүчин чадал нэлээд буураад байсан ч хурал номын орлого нь багагүй байсаар байжээ. Тухайлбал, архивын баримтаас үзэхэд, 1936 оны байдлаар тус хүрээний 25 жасын бэлэн байсан мал хөрөнгө нь адуу 44, үхэр 117, хонь 151, ямаа 9, жасуудад буй барааны үнэ 19800 төгрөг, дуганаас бусад

- барилгын үнэ 28661 төгрөг, дацан хурлуудын хурал номын орлого 16688 төгрөг, нас барагсдаас эзэмших эзэнгүй учир жасад шилжүүлсэн орлого 8560 төгрөг, ардын өргөлөөр орсон 49043 төгрөг, мал худалдсаны орлого 11253 төгрөг, түүхий эд худалдсаны үнэ 2150 төгрөг, худалдаа хийсний үнэ 13000 төгрөг, бусад орлого 50704 төгрөг бөгөөд нийт 199831 төгрөг болжээ¹⁴.

Дайчин вангийн хүрээний Монголын бусад сүм хийдүүдээс ялгарах онцлог нь үндсэн эрхлэх мал аж ахуйгаас гадна газар эзэмшиж, тариалан эрхэлж байсан явдал юм. XIX зууны эцэс гэхэд Монгол оронд газар тариалангийн дөрвөн гол

¹² МУУТА. М-14, Д-1, ХН-20.

¹³ МУУТА. М-9, Д-1, ХН-1423

¹⁴ МУУТА. М-9, Д-1, ХН-1423

голомт бий болоод байсны Төв Халхын газар тариалангийн голомт нь Орхон, Сэлэнгэ, Туул, Хараа, Ерөө голын сав дагуух нутгийг хамарч байжээ. Дайчин вангийн хүрээний тариалан нь энэ бүст хамрагдах бөгөөд тус хошууныхан үндсэн эрхлэх мал аж ахуйгаас гадна үржил шимтэй Эг, Сэлэнгэ, Орхон гол дагуу тариалангийн ажил бас эрхэлж байжээ. Энэ тухай 1910 онд Монгол орноор явсан Оросын шинжээч М.И. Боголепов, М.Н.Соболев нар "монголчуудын эрхэлдэг тариа Хануй голын гудас, Вангийн хүрээний орчим Эгийн гол ба түүний салаанууд Сэлэнгэ мөрний зах гэх газруудаар тохиолдох бөгөөд тэндээ улаан буудай, арвай, шар будаа тарина. Тариагаа хадахгүй үндэстэй нь зулгаан авна¹⁵" гэж тэмдэглэсэн буй. Вангийн хүрээний тариалан нь байгаль-газар зүйн таатай нөхцлийг ашиглан газар тариалангийн бүтээгдэхүүнээр өөрсдийн хэрэгцээг хангаж, улмаар гадагш зах зээлд гаргах сонирхолтой байжээ.

Дайчин вангийн хошууны гар урчуудын олонх нь Вангийн хүрээний ойр орчимд төвлөрч байжээ. Тиймээс Вангийн хүрээний дэргэд гар урлал нэлээд хэмжээгээр хөгжиж, бурхан бүтээх, сүм дуганыг шинэтгэн сэлбэх, зул хүжийн хэрэгсэл, бурхны тахил, цөгц зэргийг үйлдэх, зурах, ширдэх, сийлбэрлэх зэрэг ажил дэлгэрсэн байна. Вангийн хүрээний лам нарын дотор Чойжав, Лувсан, Дэмид зэрэг цуутай уран дархчууд, бар сийлдэг бурхан зураачид олон байв¹⁶. Тус хүрээний гар урчууд Вангийн хүрээнд хойч үедээ дуурсагдах олон сайхан сүм дуган, байшин барилга бариулж, Монголын уран барилгын хөгжилд багагүй хувь нэмэр оруулсан юм. 1905 онд Вангийн хүрээнд "Жаран хашор" гэх олон метр өндөр суварга бүтээн дуусгаж, 13-р Далай ламаар равнайлуулж, урт удаан бат бөх орших ерөөл хийлгэж байв. Энэ суварга боржин чулууг засаж барьсан 40 м өндөр хэмжээтэй байсан гэдэг. Вангийн хүрээнд "Диваажин" гэдэг бурхны жаргалын орныг дүрсэлсэн хот мандал бүхий сүмийг хиймэл шороон уулан дээр барьж байгуулсан нь маш уран гоё хийцтэй учир олны сонирхлыг ихэд татаж байсан ажээ.

XX зууны эхэн үед Төв Халхад хамгийн томд орох цогчин дуганыг энд барьсан нь модон барилгын хувьд тухайн үедээ дуулиантай хэрэг болж байсан ажээ. Энэ дуганы үндсэн хэсэг нь дөрвөлжин хэлбэртэй, дээд давхар нь найман тагттай байсан аж. Уг дуганы банзан ханыг цагаан өнгөөр будаж, цонх болон дээд

¹⁵ М.И. Боголепов, М.Н. Соболев. Очерки торговли русско-монгольской. Спб., 1912. стр.156

¹⁶ Булган аймаг. Эрхэлсэн Ж.Болдбаатар. Булган хот. 1988. тал 42.

давхарыг хөх ногоон өнгийн дөрвөлжин хээгээр чимэглэсэн байжээ¹⁷. Тус хүрээний гар урчууд эртний Энэтхэгийн "Бадамхатан" хэмээх хөлгөн судрыг монгол үсгээр гайхамшигтай сайхан урлан бүтээж, хошуу ноён Ханддоржид бэлэглэж байжээ.

Дурдан буй үед монголчуудын дунд худалдаа наймааны томхон суурин газрууд үүсч байсны нэг нь Вангийн хүрээ байжээ. XX зууны эхээр монгол газар явсан Оросын шинжилгээний ангийнхны ажигласнаар Монголын дотоодын таваарын гүйлгээний зам нь "Вангийн хүрээнээс гарч Орхон голыг даган явсаар Сайн ноёны өргөө хүрч, тэндээс урагшлан говь ордог. Энэ замаар Вангийн хүрээнээс гурил будаа, урд зүгийн нутгаас давс, хужир ачиж, мал тууж ирдэг¹⁸" гэжээ.

Дайчин вангийн хүрээний худалдааны голыг Хятадын пүүсний дэлгүүрүүд гүйцэтгэж байв. Тухайлбал, 1915 оны байдлаар Баярт, Заяат, Шар дэлгүүрт, Огтор буянт, Хөх хашаат, Содномдаржаагийн пүүсний дэлгүүрүүдтэй байжээ¹⁹. Судалгаанаас үзвэл, Вангийн хүрээнд Тун Чуньхэ /нэг жилийн гүйлгээ 12000 лан/, Цзюй Чэнюань /10000лан/, Дэн Фэнгэнь /6000 лан/, Дэ гэнхэ /3000 лан/, Тун Цяньюань /3000 лан/, Син Луньку /150000 лан/, И Чжунчань /80000 лан/, Дэ Лунъюй /50000лан/, Фын Тайхэнь /30000 лан/, Цзюй мунку /30000 лан/, Тянь Шунгэнь /20000 лан/, Цянь дачэнь /10000 лан/, Сиван Синдэ /10000 лан/, Дэ Шэньфынь /6000 лан/, Фу Тайхао /5000 лан/ гэсэн хятад пүүс, пүүсийн салбарууд ажиллаж байжээ²⁰.

Дайчин вангийн хошуу нь Оросын хилд ойр залгаа учир хошууны төв Вангийн хүрээнд худалдааны зах зээл Халхын бусад хошуудаас нэлээд эрт хөгжиж эхэлжээ. Тэр үед үүсч байсан худалдаачид нь их төлөв чинээлэг малчид, баян лаи нарын дундаас гарч байжээ. Тэд өөрсдийн аж ахуйгаас гарах илүүдэл бүтээгдэхүүнийг жил бүр 1-2 удаа Хүрээ, Хиагт зэрэг газруудаар явж, борлуулж, тэндээс бараа таваараа авчраад, нутагтаа худалдаж, ашиг олдог байжээ. Түүнчлэн баячуулын дотор Хятад, Оросын худалдаачдын жин тээж, ашиг олох явдал нэлээд байсан бөгөөд үүнийгээ худалдааны ажилтай хослуулдаг байжээ. Тус хошууныхан Вангийн хүрээний дээр мал, мах, цагаан идээ, түлээ, шар будаа,

¹⁷ Д.Майдар. Монголын архитектур ба хот байгуулалт. УБ., 1972. тал 23.

¹⁸ Булган зймаг. Эрхэлсэн Ж.Болдбаатар. Булган хот. 1988. тал 33.

¹⁹ Ц.Насанбалжир. Монголын аж ахуй хөтлөлтийн уламжлал шинэчлэл /1691-1911/. УБ., 1978. тал 55.

²⁰ Ар Монгол дахь Хятадын худалдаа, мөнгө хүүлэл /1751-1911/. Эмхтгэж, тайлбар хийсэн А.Очир, Г.Дашням УБ., 1988. тал 434.

арвайн гурил, үсэлсэн арвай, мөн гар урлалын бүтээгдэхүүнээ худалддаг байв. Мөн мөнгөн тэмдэгтийг төлөөлүүлэн цагаан мөнгө, цай, хятад, оросын мөнгөн тэмдэгт, хадаг хэрэглэж байжээ.

Вангийн хүрээ нь 1924 оноос Богд хан уулын аймгийн Булган уулын хошуунд, 1931 оны засаг захиргааны өөрчлөлтөөр Сэлэнгэ аймгийн Булган сумын харъяанд Булганы хүрээ хэмээн нэрлэгдэж, Монголын нөлөө бүхий хийдийн тоонд орсоор байв. Энэ тухай 1936 оны үеийн архивын баримтад "Тус хүрээ нь уулаасаа газар газар алдаршин дуурсал нэртэй нөлөө бүхий томоохон хийд мөн болох учир түүний нэр алдараар хол ойр ямар нэгэн сүсэгтнүүд ямагт тасралтгүй үргэлжлэн ирж, элдэв өргөл даатгал болон байдаг зэрэг ардыг татах сүр хүчин нь эртнээс алдаршсан²¹" гэжээ. Тэр үед тус хүрээний орчим хоршоо, улсын худалдаа, сумын захиргаа, бага сургууль, утасны хороо, хүн мал эмнэлгийн салбар, тээхийн буудал зэрэг шинэ үеийн албан байгууллагууд буй болж, ажиллаж байжээ. Гэвч 1937-1938 онд Монгол улсад явагдсан их хэлмэгдүүлэлтийн хар шуурганд тус хүрээ Монголын бусад сүм хийдийн нэгэн адил өртөж, олон зуун лам хуврагууд нь хэлмэгдэж, түүхийн туршид бүтээгдсэн түүх, шашин соёлын гайхамшигт дурсгал, сүм хийдүүд нь устаж үгүй болход хүрсэн билээ.

Abstract: In this article the author tried to clear historical development of Daichin vang monastery, the one of the ancient monastery of Northern Mongolia from the 19th c- beginning of the 20th c. Daichin van monastery founded by the activity of Baatar beil for spreading buddhism in our homeland. This monastery have passed through many stages of development during the historical process. There were over 3700 monks in the beginning of 20th c. and these monks were divided into 6 aimaks and 5 datsans. The Daichin van monastery can be considered that its been one of the economic, religious and cultural center of Khalkha at beginning of the 20th c.

²¹ ТЕГ-ын Түүхийн Архив. Ф-6, ХН-256.